



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/21

Дэлгэрхаан сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66,1 дэх хэсэг, “Газрын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээгээ шилжүүлэх хүсэлт гаргасан иргэн Б.Чанцалдулам /СЛ94060207/-н амралтын газрын зориулалттай 900 м2 газрыг иргэн Б.Шүхэрт /СИ95022219/-д 48 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (Б.Шүхэрт)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дугаар захирамжийн иргэн (Б.Чанцалдулам)-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2326910037

